



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/А50

Булган сум

Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл  
сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд  
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амд эрүүл аж төрөх дадал хэвшүүлэх, нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Сайхан Монгол” орон нутгийн телевизтэй хамтран ажиллахад Эрүүл мэндийн газарт 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг “Эрүүл Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР